ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2025/20/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Б.Мягмарсүрэн
Утас: 70593113
Цахим хаяг: Myagmarsurenby@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга** ........ 0
**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 3
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** ........ 3
**2.1 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан** ........ 5
**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/** ........ 6
**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/** ........ 8
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 8
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 9
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ **Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ **Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ **Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ **Error! Bookmark not defined.**
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ Error! Bookmark not defined.
**4.1 Ерөнхий зүйл** ........ **Error! Bookmark not defined.**
**4.2 Материаллаг байдал** ........ **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.. **Error! Bookmark not defined.**
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ **Error! Bookmark not defined.**
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ **Error! Bookmark not defined.**
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ **10**
**5.2 Албан шаардлага** ........ 10
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ **16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.24 № 19

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ӨЛЗИЙТОГТОХ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвөөс гаргах баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, жолоочийн тооцоо бодоогүй, санхүүгийн тайлан дахь өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зэрэг 76.3 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 6.8 дахин их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/"-ийн 1-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.7 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2024 онд 2 албан хаагч 16.5 сая төгрөгийн дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Сумын эмийн эргэлтийн сан ОНӨААТҮГ-уудыг татан буулгах тухай" 16 дугаар тогтоолын дагуу сумын Эмийн эргэлтийн санг

4825020063

татан буулгаж, үлдэгдэл хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайланд нэгтгэсэн онцлог бүртгэл хийгджээ.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар нь засаг даргын нөөц сангаас 41.9 сая төгрөгийн өвсний худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож, босго үнийг үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-д /Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно/, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ. /хавсралтын 2–т/ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд 20.0 сая/ тус тус заасныг зөрчсөн тул гол асуудал гэж үзэн албан шаардлага хүргүүлсэн.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт, 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 78 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 92 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 94,330,966.07 | 151,395,238.92 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 9,354,795.00 | 8,135,339.87 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 9,354,795.00 | 8,135,339.87 |
| 3121 | Төгрөг | 9,354,795.00 | 8,135,339.87 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | 50,544.87 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 9,354,795.00 | 8,084,795.00 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| 33 | АВЛАГА | 15,424,594.00 | 34,144,114.60 |
| 335 | Бусад авлага | 15,424,594.00 | 34,144,114.60 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 935,033.00 | 19,654,553.60 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 14,489,561.00 | 14,489,561.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | 2,220,000.00 |
| 346 | Урьдчилж гарсан зардал | | 2,220,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 69,551,577.07 | 106,895,784.45 |
| 351 | Түүхий эд материал | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 61,551,577.07 | 98,895,784.45 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 2,929,000.00 | 4,123,800.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 53,984,877.07 | 87,097,984.45 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 4,637,700.00 | 7,674,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,595,367,957.03 | 2,074,626,727.86 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,595,367,957.03 | 2,074,626,727.86 |
| 392 | Биет хөрөнгө | 1,568,749,331.91 | 2,048,630,415.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,353,127,830.83 | 1,885,794,505.83 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -271,429,829.17 | -336,773,169.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 300,306,950.00 | 370,292,150.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -62,789,186.49 | -117,860,896.26 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 246,958,070.00 | 252,309,199.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42,838,380.67 | -80,048,637.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,521,250.00 | 92,169,220.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,912,045.75 | -19,141,792.88 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 750,000.04 | 750,000.04 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,574,184.60 | 4,574,184.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,519,511.48 | -3,434,348.40 |
| 393 | Биет бус хөрөнгө | 26,618,625.12 | 25,996,312.64 |
| 39301 | Програм хангамж | 6,856,625.00 | 7,481,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,761,999.88 | -3,009,312.36 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,524,000.00 | 21,524,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,689,698,923.10 | 2,226,021,966.78 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,631,899.00 | 20,879,587.67 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,631,899.00 | 20,879,587.67 |
| 413 | Өглөг | 1,631,899.00 | 20,879,587.67 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,631,899.00 | 801,715.00 |
| 4136 | Бусад өглөг | | 20,077,872.67 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 20,077,872.67 |
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,688,067,024.10 | 2,205,142,379.11 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,688,067,024.10 | 2,205,142,379.11 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 462,149,763.67 | 462,149,763.67 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 462,149,763.67 | 462,149,763.67 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 974,486,471.50 | 1,491,561,826.51 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 974,486,471.50 | 974,486,471.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 517,075,355.01 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 251,430,788.93 | 251,430,788.93 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,689,698,923.10 | 2,226,021,966.78 |

## 2.1 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,003,758,689.00 | 1,630,517,612.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 427,044,554.00 | 705,056,282.23 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 427,044,554.00 | 705,056,282.23 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,661,195.00 | 7,199,894.87 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,844,500.00 | 7,149,350.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 6,816,695.00 | 50,544.87 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 410,383,359.00 | 668,097,274.62 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 29,759,112.74 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 576,714,135.00 | 925,461,329.87 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 25,529,335.00 | 50,527,029.87 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,885,707.00 | 20,442,222.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,643,628.00 | 30,084,807.87 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 551,184,800.00 | 874,934,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 551,184,800.00 | 874,934,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 676,474,888.90 | 1,090,372,527.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 676,474,888.90 | 1,065,372,527.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 551,543,050.41 | 950,072,715.85 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 251,108,895.00 | 441,502,079.00 |
| 210101 | Үндсэн цалин | 192,804,389.00 | 281,794,975.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,222,504.00 | 145,275,604.00 |
| 210104 | Урамшуулал | 17,082,002.00 | 14,431,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,962,015.00 | 52,808,580.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,414,069.00 | 37,527,657.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,582,123.00 | 4,415,023.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,017,129.00 | 2,343,616.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 355,997.00 | 1,704,457.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,592,697.00 | 6,817,827.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,096,152.51 | 35,377,203.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,355,014.51 | 6,569,079.64 |
| 210302 | Түлш, халаалт | 25,741,138.00 | 28,808,123.42 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,977,534.40 | 46,140,069.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,356,500.00 | 2,222,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,013,680.00 | 37,156,045.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,503,800.00 | 3,144,850.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.00 | 2,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,603,554.40 | 1,117,024.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,285,000.00 | 18,004,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,285,000.00 | 18,004,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,912,000.00 | 28,940,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,912,000.00 | 28,940,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,325,294.00 | 12,265,834.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,658,100.00 | 10,640,350.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 103,950.00 | 916,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 260,216.00 | 386,361.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 226,028.00 | 246,123.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 156,876,159.50 | 315,034,450.19 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,616,526.00 | 125,803,280.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 2,750,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 122,259,633.50 | 186,481,170.19 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,931,838.49 | 115,299,811.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,024,800.00 | 31,490,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 7,800,000.00 | 5,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,317,800.00 | 6,730,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 9,110,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,907,000.00 | 10,650,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 108,907,038.49 | 83,809,811.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,907,038.49 | 83,809,811.21 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 25,000,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 25,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 25,000,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 327,283,800.10 | 540,145,085.04 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,054,049.01 | 23,069,730.03 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 6,054,049.01 | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 786,335.07 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | | 2,698,333.60 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | | 19,585,061.36 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -6,054,049.01 | -23,069,730.03 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 321,229,751.09 | 517,075,355.01 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 593,375,330.00 | 933,582,374.74 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 16,661,195.00 | 8,121,044.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 16,661,195.00 | 8,121,044.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,661,195.00 | 8,121,044.87 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,844,500.00 | 8,070,500.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 6,816,695.00 | 50,544.87 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 576,714,135.00 | 925,461,329.87 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 25,529,335.00 | 50,527,029.87 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,885,707.00 | 20,442,222.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,643,628.00 | 30,084,807.87 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 551,184,800.00 | 874,934,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 551,184,800.00 | 874,934,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 554,790,535.00 | 908,539,679.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 554,790,535.00 | 908,539,679.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 429,858,696.51 | 793,239,868.66 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 251,471,911.00 | 440,930,062.00 |
| 210101 | Үндсэн цалин | 193,167,405.00 | 281,222,958.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,222,504.00 | 145,275,604.00 |
| 210104 | Урамшуулал | 17,082,002.00 | 14,431,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,534,032.00 | 52,808,580.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,986,086.00 | 37,527,657.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,582,123.00 | 4,415,023.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,017,129.00 | 2,343,616.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 355,997.00 | 1,704,457.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,592,697.00 | 6,817,827.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,464,253.51 | 36,207,387.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,355,014.51 | 6,569,079.64 |
| 210302 | Түлш, халаалт | 24,109,239.00 | 29,638,307.42 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,665,280.00 | 44,441,528.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,032,500.00 | 3,407,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,016,000.00 | 31,942,728.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,503,800.00 | 4,364,850.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,829,180.00 | 2,766,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,283,800.00 | 1,960,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 308,000.00 | 1,080,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 308,000.00 | 1,080,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,174,400.00 | 24,446,590.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,174,400.00 | 24,446,590.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,912,000.00 | 28,940,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,912,000.00 | 28,940,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,503,294.00 | 13,265,834.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,658,100.00 | 11,640,350.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 103,950.00 | 916,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 260,216.00 | 386,361.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 178,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 226,028.00 | 246,123.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,825,526.00 | 151,119,887.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,488,026.00 | 148,369,887.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,337,500.00 | 2,750,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,931,838.49 | 115,299,811.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,024,800.00 | 31,490,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 7,800,000.00 | 5,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,317,800.00 | 6,730,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 9,110,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,907,000.00 | 10,650,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 108,907,038.49 | 83,809,811.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,907,038.49 | 83,809,811.21 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 38,584,795.00 | 25,042,694.87 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 29,580,000.00 | 25,341,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 29,580,000.00 | 25,341,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 25,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 29,580,000.00 | 341,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -29,580,000.00 | -25,341,000.00 |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,354,795.00 | -298,305.13 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 9,354,795.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,354,795.00 | 8,135,339.87 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 462,149,763.67 | 251,430,788.93 | 464,405,247.80 | 491,262,444.88 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,300,000.00 | 2,300,000.00 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 14,218,778.82 | | 14,218,778.82 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 507,781,223.70 | 507,781,223.70 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 462,149,763.67 | 251,430,788.93 | 974,486,471.50 | 1,688,067,024.10 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 517,075,355.01 | 517,075,355.01 |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 462,149,763.67 | 251,430,788.93 | 1,491,561,826.51 | 2,205,142,379.11 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 876,934,300.00 | 806,747,101.74 | 70,187,198.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 816,934,300.00 | 781,747,101.74 | 35,187,198.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 783,152,300.00 | 750,257,101.74 | 32,895,198.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 461,924,000.00 | 440,930,062.00 | 20,993,938.00 |
| 210101 | Үндсэн цалин | 283,164,700.00 | 281,222,958.00 | 1,941,742.00 |
| 210102 | Нэмэгдэл | 149,219,200.00 | 145,275,604.00 | 3,943,596.00 |
| 210104 | Урамшуулал | 29,540,100.00 | 14,431,500.00 | 15,108,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,123,400.00 | 52,808,580.00 | 3,314,820.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,331,000.00 | 37,527,657.00 | 1,803,343.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,653,100.00 | 4,415,023.00 | 238,077.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,766,500.00 | 2,343,616.00 | 422,884.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,676,500.00 | 1,704,457.00 | -27,957.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,696,300.00 | 6,817,827.00 | 878,473.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,571,800.00 | 35,034,458.14 | 537,341.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,433,000.00 | 5,396,150.72 | 36,849.28 |
| 210302 | Түлш, халаалт | 29,638,800.00 | 29,638,307.42 | 492.58 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | | 500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,403,700.00 | 32,348,130.00 | 1,055,570.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,433,500.00 | 3,407,950.00 | 25,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,200,200.00 | 20,189,330.00 | 10,870.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,154,000.00 | 4,024,850.00 | 129,150.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,654,000.00 | 2,766,000.00 | 888,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,962,000.00 | 1,960,000.00 | 2,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,100,000.00 | 1,080,000.00 | 20,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,100,000.00 | 1,080,000.00 | 20,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,000,000.00 | 20,994,500.00 | 1,005,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,000,000.00 | 20,994,500.00 | 1,005,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 29,113,400.00 | 28,940,000.00 | 173,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,113,400.00 | 28,940,000.00 | 173,400.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,609,700.00 | 4,381,984.60 | 1,227,715.40 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,761,700.00 | 2,756,500.00 | 5,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 916,000.00 | 916,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 528,000.00 | 386,361.60 | 141,638.40 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,000.00 | 77,000.00 | 133,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 684,000.00 | | 684,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 510,000.00 | 246,123.00 | 263,877.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,306,300.00 | 133,739,387.00 | 4,566,913.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,556,300.00 | 130,989,387.00 | -20,433,087.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,750,000.00 | 2,750,000.00 | 25,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 33,782,000.00 | 31,490,000.00 | 2,292,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,782,000.00 | 31,490,000.00 | 2,292,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 5,000,000.00 | 5,000,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,550,000.00 | 6,730,000.00 | 1,820,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,582,000.00 | 9,110,000.00 | 472,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,650,000.00 | 10,650,000.00 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 60,000,000.00 | 25,000,000.00 | 35,000,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 60,000,000.00 | 25,000,000.00 | 35,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 60,000,000.00 | 25,000,000.00 | 35,000,000.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 876,934,300.00 | 807,668,251.74 | 70,187,198.26 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 874,934,300.00 | 804,597,751.74 | 70,336,548.26 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 874,934,300.00 | 804,597,751.74 | 70,336,548.26 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,000,000.00 | 2,149,350.00 | -149,350.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,149,350.00 | -149,350.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 50,527,029.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 50,527,029.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 37,053,766.92 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,172,928.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,172,928.92 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,093,398.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,753,398.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 340,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,452,090.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,452,090.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,883,850.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,883,850.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,451,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,451,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,473,262.95 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,473,262.95 |

| | | |
|---|---|---|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | |
| | Дотоод эх үүсвэрээр | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 50,527,029.87 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,527,029.87 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,442,222.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 30,084,807.87 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 85,483.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 3,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 82,483.2 мянган төгрөгийн 5 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар эм эргэлтийн сангийн 3,000.0 мянган төгрөгийн эмийн авлагыг дутуу бүртгэж тайлагнасан 1 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 82,483.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчил арилгах албан шаардлага хүргүүллээ.

### 3.1 Албан шаардлага

- Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 15,506.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь 1-д /Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/ заасныг тус тус зөрчсөн.
- Өвсний худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож, босго үнийг үнийг мөрдөлгүй 41,906.9 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-д /Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно/, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралт /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ./, хавсралтын 2–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 20.0 сая/ заасныг тус тус зөрчсөн.
- Нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1,471.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/ 15.1.3 дахь /Хууль тогтоомжид заасснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “/Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заасныг тус тус зөрчсөн.
- Санхүүгийн тайлан дахь 23,119.80 мянган төгрөгийн авлага, 478.70 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.

- Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч У.Сүнжидмаа нь өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой дараах зөрчлүүдийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй. Үүнд:
  - Байгууллагын албан хэрэгцээнд шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.

  Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ заасныг,

  - Тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан.

  Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д /өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;/, 70 дугаар зүйлийн 70.2-т /Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т /Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:/, 20 дугаар зүйлийн 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн аудитаар зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүллээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эм эргэлтийн сангийн эмийн авлагыг дутуу бүртгэж тайлагнасан. | 1 | 3,000.0 | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **3,000.0** | **1** | **3,000.0** | | | **1** | **3,000.0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан. | 1 | 15,506.8 | | | 1 | 15,506.8 | | | | |
| | | | | | | | | | | |
| Санхүүгийн албаны ажилтнуудын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон болович албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан, аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгосон байна. | 1 | 1,471.0 | | | 1 | 1,471.0 | | | | |
| Санхүүгийн тайлан дахь өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. | 2 | 23,598.5 | | | 1 | 23,598.5 | | | | |
| Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан. /Хөрөнгийн тооллого санхүүгийн тайлангаас зөрүүтэй, жолоочийн тооцоог бодоогүй/ | 1 | 0 | | | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **5** | **40,576.3** | | | **3** | **40,576.3** | | | **1** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Өвсний худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож, босго үнийг үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн. | 1 | 41,906.9 | | | 1 | 41,906.9 | | |
| | | | | | | | | |
| Дүн | **1** | **41,906.9** | | | **1** | **41,906.9** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |